

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**БҮХ ХЯТАДЫН АРДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЗУРГАА ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН АНХДУГААР
ЧУУЛГАНЫ ТУХАЙ**

БХАТХ-ын зургаа дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1983 оны 6-р сарын 6-аас 21-ний өдрүүдэд Бээжинд болов. Их хурлын төлөөлөгчөөр 2978 хүнийг сонгосноос ажилчин, тариачин—791 хүн, боловсрол, шинжлэх ухаан-техникийн ажилтан зэрэг сэхээтэн—701 хүн, БНХАУ-ын 55 цөөнх үндэстний 403 хүн байсан бөгөөд үлдсэн хэсэг нь кадр ажилтан (ганьбу) нар, армийн төлөөлөгчид болон олон ардчилсан нам, байгууллага, эх орондоо буцаж ирсэн хятад иргэд (хуацяо), Тайваний гаралтай иргэдийн төлөөлөгчид байв. Их хуралд сонгогдсон төлөөлөгчдийн 37,5% нь нам бусчууд байв.

БХАТХ-ын зургаа дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганд засгийн газрын ажлын тухай тайлан илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян, Улс ардын аж ахуй, нийгмийг хөгжүүлэх 1983 оны төлөвлөгөөний тухай илтгэлийг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч, Улсын төлөвлөгөөний Комиссын дарга Яо Илин, 1982 оны улсын төсвийн гүйцэтгэлийн тухай илтгэлийг БНХАУ-ын Сангийн Яамны сайд Ван Бинцянь БХАТХ-ын Байнгын Хорооны ажлын тухай илтгэлийг тав дахь удаагийн сонгуулийн БХАТХ-ын Байнгын Хорооны орлогч дарга бөгөөд нарийн бичгийн дарга Ян Шанкунь, Ардын Дээд Шүүхийн ажлын тухай илтгэлийг Ардын Дээд Шүүхийн дарга Цзян Хуа, Ардын Дээд Прокурорын Газрын ажлын тухай илтгэлийг Ардын Дээд Прокурорын Газрын ерөнхий прокурор Хуан Хоцин нар тавив.

Чуулганыг нээж БХАТХ-ын Байнгын Хорооны орлогч дарга Пэн Жэнь хэлэхдээ, 1982 оны сүүлээр болсон тавдугаар чуулганаар баталсан шинэ Үндсэн хууль нь хятадын онцлогыг харгалзан үзэж, «дөрвөн шинэчлэлтийн» бодлогыг хэрэгжүүлэхэд тохирсон социалист Үндсэн хууль юм гэж тэмдэглэв.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жао Зыян засгийн газрын ажлын тухай илтгэлдээ эдийн засгийн хөгжлийн асуудал, БНХАУ-ын гадаад бодлогын үндсэн чиглэлийн талаар тодорхой яриу. Тэр хөдөө аж ахуй, хөнгөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт түргэн хурдацтай байгааг тэмдэглээд, хятадын хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах ажилд олон жил үргэлжилсэн хүнд байдал тодорхой хэмжээгээр сайжирч, үүний өмнө картаар худалдаж байсан олон нэр төрлийн өргөн хэрэгцээний аж үйлдвэрийн барааг одоо чөлөөтэй худалдаж байна гэж тэмдэглэв. Гэтэл одоо Хятадад хөдөлмөрчдийн өргөн хэрэгцээний хөвөн бөс бараа, түүгээр хийсэн зарим бүтээгдэхүүн, унадаг дугуй, оёдлын машин болон хүн амын хүнсний өдөр тутмын өргөн хэрэгцээний гурил, будаа, ургамлын тос, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүнийг картын системээр хуваарилсан хэвээр байгаа билээ.

Тус орны улс ардын аж ахуйг зохих ёсоор зохицуулж үйлдвэр аж ахуйн газрын техникийн өөрчлөлтийг түргэсгэн эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхийг Жао Зыян уриалаад, хөдөө аж ахуй, хөнгөн болон хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэхэд адилхан анхаарч түлш-эрчим хүч, тээврийн болон бусад нэн чухал барилга байгууламж барих ажлыг эрчимтэй болгохын чухлыг цохон тэмдэглэв.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд тус орны батлан хамгаалах хүч чадал бэхжиж байгааг онцлон тэмдэглэв. Түүний хэлснээр ХАЧА-ийг орчин үеийн дайны нөхцөлд байлдааны төрөл бүрийн ажиллагаа явуулах ур чадвар бүхий байнгын арми болгохын тулд армийг шинэчлэх ажлыг түргэтгэх хэрэгтэй ажээ.

Улсыг аюулаас хамгаалах, сөрөг тагнуулын ажиллагааг хүчтэй болгох зорилгоор Улсыг Аюулаас хамгаалах Яам байгуулах саналыг Жао Зыян чуулганд оруулав. Үүнийг чуулган хүлээн авч БНХАУ-ын Улсыг Аюулаас хамгаалах Яамыг байгуулах тухай шийдвэр гаргав.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд илтгэлийнхээ гадаад бодлогын хэсэгт АНУ, Өрнөд Европын орнууд, дэлхийн бусад бүс нутгийн оронтой БНХАУ харилцаж байгаа асуудлыг хөндөж яриулав. Жао Зыян БНХАУ, АНУ-ын хоорондын харилцааны талаар ярихдаа: «Хятадын засгийн газар, хятадын ард түмэн хятад-америкийн харилцааг ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байгаа боловч улс орныхоо бүрэн эрхт өнгөлзсөн явууллага үйлдүүлж, дотоод хэрэгтээ хөндлөнгөөс хэрхэвч оролцуулахгүй» гэв. Энэ нь АНУ-аас Тайванийг дэмжиж, түүнд орчин үеийн зэвсэг нийлүүлэн, «хоёр хятадын» бодлого явуулж байгаад хятадын удирдлага дургүйцэж байгаа хэрэг юм.

БНХАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны талаар Жао Зыян ярихдаа, Зөвлөлтийн зүгээс Хятад улсын аюулгүй байдалд «заналхийлж» байгаа мэтээр гүтгэлэг хийсний зэрэгцээ «Хятад-зөвлөлтийн харилцаа удаан хугацаагаар түгшүүртэй байгаа нь аль аль талд ашиг тус өгөхгүй байгаа болон хоёр орны ард түмэн энэ харилцааг хэвийн болгохыг хоёул сонирхож байгааг» зөвшөөрөн хүлээв. Хятадын удирдлагын ажил явууллагын уршгаар зөвлөлт-хятадын харилцаа олон жилийн турш түгшүүртэй болж, уг харилцааг хэвийн болгох талаар ЗСБНХУ-ын удаа дараа дэвшүүлсэн оновчтой саналыг Хятадын тал хүлээн авч биелүүлэхээс татгалзаж байгаагийн зэрэгцээ гуравдахь орны эрх ашгийг хөндсөн хүлээж авч болшгүй болзол шаардлагыг сөргүүлэн тавьж байгаа нь хэн бүхэнд мэдээж билээ.

БНХАУ, БНСВУ-ын харилцааны тухай Жао Зыян хэлэхдээ, Вьетнам нь Энэтхэг-хятадын хойг, Зүүн-өмнөд Азид «орон нутгийн жанжлал» явуулж, Кампучид «түрэмгийлэл» үйлдэж байгаа мэтээр социалист Вьетнамыг гүтгэн дайрав.

Зургаа дахь удаагийн сонгуулийн БХАТХ-ын анхдугаар чуулган БНХАУ-ын даргаар Ли Сяньнянь, орлогч даргаар Улаанхүү, БХАТХ-ын Байнгын Хорооны даргаар Пэн Жэнь; орлогч даргаар Чэнь Писянь, Вэй Гоцин, Гэн Бяо, Ху Цзюевэнь, Сюй Дэхэн, Пэн Чун, Ван Жэньчжун, Ши Лян, Чжу Сюефань, Нгапод-Агваанжигмэд, Ванчинэрдэнэ-Чойжижанцан, Сайфуддин, Чжоу Гучэн, Ян Цзицы, Ху Юйчжи, Жун Ижэнь, Е Фэй, Ляо Ханьшэн, Хань Сяньчу, Хуан Хуа нарыг, нарийн бичгийн даргаар Ван Ханьбинийг, гишүүнээр 133 хүнийг, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн даргаар Дэн Сяопиныг, БНХАУ-ын Ардын Дээд Шүүхийн даргаар Чжэн Тяньсяныг, БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын Газрын ерөнхий прокурор Ян Ичэнийг сонгож, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдаар Жао Зыян, БНХАУ-ын Цэргийн Төв Зөвлөлийн орлогч даргаар Е Цзяньин, Сюй Сянцян, Не Жунчжэнь,

Ян Шан-кунь, гишүүдээр Юй Цюли, Ян Дэчжи, Чжан Айпин, Хун Сюечж нарыг томилох шийдвэр гаргав.

Зургаа дахь удаагийн сонгуулийн БХАТХ-ын зургаан комиссыг байгуулав. Үүнд: Үндэстний асуудал эрхлэх комисс (дарга нь НгаподАгваанжигмэд орлогч дарга нар-6, гишүүд-7); Хуулийн комисс (дарга нь Пэн Чунь, орлогч дарга нар-5, гишүүд-7); Санхүү. эдийн засгийн комисс (дарга нь Ван Жэньчжун, орлогч дарга нар-5, гишүүд-8); Гэгээрэл, шинжлэх ухаан, соёл, эрүүлийг хамгаалах асуудлын комисс (дарга нь Чжоу Гучэн, орлогч дарга нар-5, гишүүд-11); Гадаад хэргийн комисс (дарга нь Гэн Бяо, орлогч дарга нар-5, гишүүд-4); Гадаадад оршин суугаа хятад иргэдийн хэрэг эрхэлсэн комисс (дарга нь Е Фэй орлогч дарга нар-3, гишүүд-5) эдгээр болно.

Мөн чуулганы шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын даргын зарлигаар Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогчоор Вань Ли, Го Илинь, Ли Пэь, Тянь Зиюнь нарыг, гишүүдээр Фан И, Гу Му, Кан Шиэнь, Чэнь Мухуа, Цзи Пэнфэй, Чжан Цзинфу, Чжан Айпин, У Сюецянь, Ван Бинцянь, Сун Пин нарыг, нарийн бичгийн даргаар Тянь Зиюнийг, Гадаад явдлын Яамны сайдаар У Сюецянийг, Батлан хамгаалах Яамны сайдаар Чжан Айпиныг-Улсын Төлөвлөгөөний Комиссын даргаар Сун Пиныг, Улсын Аюулаас хамгаалах Яамны сайдаар Лин Юнь зэрэг 45 яамны сайд, улсын хороо, комиссын дарга нарыг томилов.

БХАТХ-ын зургаадахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1983 оны 6-р сарын 21-нд Бээжинд дуусч, төгсгөлийн хуралдаан дээр БНХАУ-ын дарга Ли Сяньнянь, БХАТХ-ын Байнгын Хорооны дарга Пэн Жэнь нар үг хэлэв. Ли Сяньнянь хэлсэн үгэндээ, БНХАУ-ыг цаашид хөгжүүлэхийн тулд: «социалист зам; ард түмний ардчилсан диктатур: коммунист намын удирдлага, марксизм-ленинизм, Мао Зэдуны үзэл санаа; энэ дөрвөн үндсэн зарчмыг хатуу баримтлана» гэв. Үүнээс үзэхэд, Хятадын одоогийн удирдагчид ХКН, төрийн дотоод, гадаад бодлогод «Мао Зэдуны үзэл санааг» тухайн нөхцөлд тохируулан удирдлага болгохоо ний нуугүй ярьж байгаа нь тодорхой байна.

Н. Батаа